



Төрийн Тусгай Албан  
Хаагчдын Нэгдсэн Эмнэлэг  
Амжилтын төлөө өөрчлөлт

**ПРИНТЕРИЙН ХОР  
(ЦАХИМ ИСТОРИ) НИЙЛҮҮЛЭХ ҮНИЙН  
САНАЛ АВАХ БАРИМТ БИЧИГ**

Төслийн нэр: Принтрийн хор (цахим истори хэвлэх)  
нийлүүлэгчийг сонгон шалгаруулах

Төслийн дугаар: ТТАХНЭ/202012015

УЛААНБААТАР ХОТ

2020 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 10-НЫ ӨДӨР

## Нэг. УРИЛГА

2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр

**Үнийн санал шалгаруулалтын нэр:** “Принтерийн хор (Цахим өвчний түүх хэвлэх) нийлүүлэх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер”

**Үнийн санал шалгаруулалтын дугаар:** ТТАХНЭ/202012015

**Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг нь** эрх бүхий тендерт оролцогчоос *“Принтерийн хор (Цахим истори хэвлэх) нийлүүлэх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер”-г* гүйцэтгэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Цахим тендер зохион байгуулах журмын дагуу тендерт оролцох хураамж 50,000 */тавин мянган/* төгрөгийг [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) –ээр банкны цахим төлбөр тооцооны системийг ашиглан төлнө.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг ажлын 7 хоног **2020 оны 01-р сарын 21-ний өдрийн 12 цаг**-аас өмнө **худалдан авах ажиллагааны цахим сайт болох [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn)** хаягаар ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2020 оны 01-р сарын 21-ний өдрийн 12 цаг 30 минутад** нээнэ.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг**

**6 давхар Захиргааны хэсэг 617 тоот**

**Утас: 99760682, [Gegee\\_76@yahoo.com](mailto:Gegee_76@yahoo.com)**

### **Нэг. ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА**

- 1. Эрх бүхий оролцогч ба эрх бүхий бараа**
  - 1.1. Үнийн саналд оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Шалгуур үзүүлэлтэнд заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Үнийн санал ирүүлэх, нээлт**
  - 2.1. Захиалагч нь ирүүлсэн үнийн саналын баримт бичиг Шалгуур үзүүлэлтэнд заасан захиалагчийн хаягаар, заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
  - 2.2. Баримт бичгийг Шалгуур үзүүлэлтэнд заасан хугацаанд, заасан газар нээлтийг хийнэ.
- 3. Баримт бичгийн иж бүрдэл**
  - 3.1. Оролцогчийн бэлтгэж ирүүлэх баримт бичиг нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
    - (а) Үнийн санал;
    - (б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;
    - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
    - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
    - (д) Татварын ерөнхий газрын тодорхойлолт
- 4. Тогтмол үнэ**
  - 4.1. Оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
- 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд**
  - 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн ирүүлсэн саналаас татгалзана.
  - 5.2. Оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.
- 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
  - 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 10 хоногийн хугацаанд хүчинтэй байна.
- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
  - 7.1. Оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
  - 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь Шалгуур үзүүлэлтэнд заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
  - 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
  - 8.1. Захиалагч нь шалгарсан оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

**Хоёр. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ**

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
<p><b>ОӨЗ 1.1</b></p>	<p><b>Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо:</b> 2018, 2019 он</p> <p><b>Сүүлийн хоёр жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажил:</b> 2018 болон 2019 онуудад тус бүр ижил төрлийн гэрээ 3-аас доошгүй гэрээ ирүүлнэ.</p> <p><b>Эрх бүхий оролцогч дараах нэмэлт материалыг тендерт хавсралтаар ирүүлнэ. Үүнд:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Шүүхийн төрөлжсөн архивын тодорхойлолт;</li> <li>• Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт;</li> <li>• Татварын цахим тодорхойлолт;</li> <li>• Нийгмийн даатгалын байгууллагын тодорхойлолт;</li> <li>• Хугацаа хэтэрсэн зээлийн өртэй эсэх тухай харилцагч банкны тодорхойлолт;</li> <li>• Бараа нийлүүлэлтийн хуваарь;</li> <li>• Худалдагч тал валютын ханшны өөрчлөлт, онцгой албан татвар нэмэгдэх болон гэрээний хугацаанд гарах аливаа асуудлыг бие даан хариуцах ба гэрээний үнэд нөлөөлөхгүй гэсэн албан бичгээр ирүүлэх</li> <li>• Гүйцэтгэгчээр шалгарсан оролцогч барааг техникийн тодорхойлолтын дагуу нийлүүлэх, уг техникийн тодорхойлолтод заасан шаардлагыг бууруулсан талаарх дүгнэлт, хэрэглэгчийн гомдол, шаардлага гарсан тохиолдолд гэрээг цуцалж, дараагийн шаардлага хангасан оролцогчтой гэрээ байгуулахыг зөвшөөрсөн тодорхойлолт;</li> <li>• Тендерийн баримт бичгийн гэрээний Ерөнхий болон Тусгай нөхцөл, маягт зэргийг зөвшөөрч байгаа талаар мэдэгдэл ирүүлнэ.</li> </ul>
<p><b>ТӨӨЗ 2.1</b></p>	<p>Үнийн санал хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: <b>УБ хот, ЧД-ийн 4-р хороо, Хуульчдын гудамж</b></p> <p>Давхар болон өрөөний дугаар: <b>ТТАХНЭ-ийн 6-р давхар 617 тоот</b></p> <p>Огноо: <b>2020 оны 01 дүгээр сарын 21-ны өдөр</b></p> <p>Цаг: <b>12 цаг 00 минут</b></p>
<p><b>ТӨӨЗ 3.1</b></p>	<p>Баримт бичгийн талаар тодруулга авах хүсэлтийг хүлээн авах эцсийн хугацаанаас өмнө ажлын 5 хоногоос багагүй байна.</p>
<p><b>ТӨӨЗ 3.2</b></p>	<p>Оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэх ба холбогдох бүх бичиг баримт нь Монгол хэл дээр байна.</p>
<p><b>ТӨӨЗ 3.3</b></p>	<p>Оролцогч Монгол улсын гадна үйлдвэрлэгдсэн бараа нийлүүлэхтэй холбогдуулан үнийг бусад валютаар санал болгон ирүүлэхийг “зөвшөөрөхгүй.”</p>
<p><b>ТӨӨЗ 3.4</b></p>	<p>Барааг нийлүүлсний дараах засвар, үйлчилгээ: “шаардлагагүй”</p>
<p align="center"><b>Д. Тендерийг нээх</b></p>	

<p><b>ТӨӨЗ 28.1</b></p>	<p>Тендерийн нээлт хийх газрын хаяг нь дор өгөгдөв. Үүнд:          Байшин, гудамжны нэр: <b>УБ хот, ЧД-ийн 4-р хороо Хуульчдын гудамж</b>          Давхар болон өрөөний дугаар: <b>А блокийн 6 давхар Хурлын танхим 605 тоот</b>          Улс: <b>“Монгол Улс”</b>          Тендерийн нээлт хийх огноо, цаг нь:          Ноо: <b>2020 оны 01 дүгээр сарын 21-ний өдөр</b>          Цаг: <b>12 цаг 30 минут</b></p>
<p><b>Е. Гэрээ байгуулах эрх олгох</b></p>	
<p><b>ТӨӨЗ 40.1</b></p>	<p>Захиалагч барааны тоо хэмжээг бууруулж болох хамгийн их хувь: <b>20</b>          Нийлүүлэх барааны тоо хэмжээг өсгөж болох хамгийн их хувь: <b>20</b></p>

## Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

1. **Барааны тодорхойлолт:** *“Принтерийн хор (Цахим истори хэвлэх)*
2. **Стандарт:** *Тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно*
3. **Баглаа, боодол:** *Нийлүүлэх барааны хайрцаг сав, баглаа боодол нь бүрэн бүтэн байх бөгөөд үйлдвэрлэгч компанийн мэдээллийг бүрэн агуулсан стандартад нийцсэн байна.*

**Бараа хүргэх газар: Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг**

4. **Бараа нийлүүлэлтийн хуваарь:**

### БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8
Бичгийн цаас	А-4 210x297 мм 80 гр хэмжээтэй, 500 ширхэгтэй, чанартай Double A эсвэл дүйцэхүйц байх.	700	ширхэг	ТТАХНЭ	Нийлүүлэх хугацааг гэрээ байгуулах үед тохирно.		
Принтерийн хор	“Konica Minolta bizhub-283” принтерт тохирсон, чанартай, үйлдвэрлэлийн лац хайрцагтай байх	13	ширхэг	ТТАХНЭ			
Принтерийн бул солих	“Konica Minolta bizhub-283” принтерт тохирсон, чанартай, үйлдвэрлэлийн лац хайрцагтай байх	2	ширхэг	ТТАХНЭ			
Принтерийн хор 104S	Чанартай, үйлдвэрлэлийн лац хайрцагтай байх	8	ширхэг	ТТАХНЭ			
Принтерийн хор 111S	Чанартай, үйлдвэрлэлийн	8	ширхэг	ТТАХНЭ			
Принтерийн хор 101S	лац хайрцагтай байх	90	ширхэг	ТТАХНЭ			

Принтерийн хор 85А	Чанартай, үйлдвэрлэлийн	30	ширхэг	ТТАХНЭ		
Принтерийн хор 35А	пац хайрцагтай байх	30	ширхэг	ТТАХНЭ		
Принтерийн хор 12А	Чанартай, үйлдвэрлэлийн	8	ширхэг	ТТАХНЭ		
Принтерийн хор 17А	пац хайрцагтай байх	8	ширхэг	ТТАХНЭ		
Принтерийн хор 78А	Чанартай, үйлдвэрлэлийн	8	ширхэг	ТТАХНЭ		

## Дөрөв. ЖИШИГ МАЯГТ

### 1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа

1. Бид, [оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

## 2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/фак с	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

## Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- |   |  |
|---|--|
| <b>1. Шалгах болон турших</b>                             | 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Захиалагчид нийлүүлж байгаа бараа бүтээгдэхүүнийхээ чанарын баталгааг гаргаж өгнө. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана. |
| <b>2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт</b> | 2.1. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ.                    |
| <b>3. Оюуны өмчийн эрх</b>                                | 3.1. Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.   |
| <b>4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх</b>     | 4.1. Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.   |
| <b>5. Баталгаат засварын хугацаа</b>                      | 5.1. Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа [6 сар] байна.   |
| <b>6. Гэрээнд өөрчлөлт оруулах</b>                        | 6.1. Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.  |
| <b>7. Төлбөр</b>  | 7.1. Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш [ГТН-д заасан тоо] хоногийн дотор шуурхай хийнэ.  |
| <b>8. Бараа нийлүүлэх хуваарь</b>                         | 8.1. Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.  |
| <b>9. Алданги оногдуулах</b>                              | 9.1. Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.   |
| <b>10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах</b>         | 10.1. Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.  |
| <b>11. Маргааныг шийдвэрлэх</b>                           | 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.   |

## Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

1. Шалгах болон турших (ГЕН – 1)
  - 1.1. Шаардлагатай тохиолдолд лабораторийн шинжилгээнд хамруулна.
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)
  - 2.1. Нийлүүлэгч техникийн тодорхойлолтын шаардлагын дагуу барааг нийлүүлнэ. Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байх ба нийлүүлэгдэх бараа нь шинэ, урьд өмнө ашиглагдаагүй, гэмтэл согоггүй бөгөөд хамгийн сүүлийн буюу өнөөгийн загварын, техникийн тодорхойлолтод бүрэн нийцсэн орчин үеийн шинэлэг ололтуудыг агуулсан байна.
3. Баталгаат засвар (ГЕН-5)
  - 3.1. Баталгаат засварын тусгай шаардлага. Нийлүүлсэн бүтээгдэхүүнийг хүлээлцэх явцад гарсан гологдлыг тухай бүр шинэчлэн сольж өгнө.
4. Төлбөр (ГЕН – 7)
  - 4.1. Гэрээний дагуу нийлүүлэгчид төлөх төлбөрийн хэлбэр, нөхцөлийг ГТН-д дурдана.
  - 4.2. “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 43 дугаар зүйлийн 43.6 дах заалтын дагуу чанарын баталгаат хугацаанд 5 хувийн барьцаа төлнө.
5. Алданги оногдуулах (ГЕН - 9)
  - 5.1. Алданги оногдуулах хувь: Хугацаа хэтэрсэн 7 хоног тутамд 0,5%
  - 5.2. Алдангийн нийт дүн: 10%-иас хэтрэхгүй байна.

Долоо. ГЭРЭЭНИЙ МАЯГТ

Гэрээ байгуулахад харилцан тохиролцож өөрчлөлт оруулна.

БАТЛАВ.

ХИАЛАГЧ

НИЙЛҮҮЛЭГЧ

\_\_\_\_\_  
(Тамга, тэмдэг)  
\_\_\_\_\_  
(Гарын үсэг)  
\_\_\_\_\_  
(Албан тушаал)

\_\_\_\_\_  
(Тамга, тэмдэг)  
\_\_\_\_\_  
(Гарын үсэг)  
\_\_\_\_\_  
(Албан тушаал)

**[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.**

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_\_ оны \_\_ сарын \_\_\_\_ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]**-г (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг \_\_\_\_\_ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь \_\_\_\_\_ нэр төрлийн барааг \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_\_\_ -наас \_\_\_\_\_ оны \_\_ дугаар сарын \_\_\_\_ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;  
Бусад шаардлагатай баримт бичиг;  
Үнийн санал;  
Гэрээний тусгай нөхцөл;  
Гэрээний ерөнхий нөхцөл;  
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;  
Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт

бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:** *[Албан тушаал, нэр]*

*[Гарын үсэг]* \_\_\_\_\_

ТАМГА

*[Захиалагчийн хаяг]*

*[Утас/факсын дугаар]*

*[Харилцагч банкны нэр, дансны дугаар]*

**НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

*[Албан тушаал, нэр]*

*[Гарын үсэг]* \_\_\_\_\_

ТАМГА

*[Захиалагчийн хаяг]*

*[Утас/факсын дугаар]*

*[Харилцагч банкны нэр, дансны дугаар]*